



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 150

Улаанбаатар хот

Хорооны 2013 оны 506 дугаар тогтоолоор
батлагдсан журамд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 506 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4 дэх хэсгийг дараах байдлаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг:

“9.1. Арилжаа эрхлэх болон төлбөр, тооцоо, хадгаламжийн байгууллагын гүйцэтгэх захирлыг томилохыг зөвшөөрөх тухай шийдвэрийг Хороо, бусад зохицуулалттай этгээдийн гүйцэтгэх захирлыг томилохыг зөвшөөрөх тухай шийдвэрийг Хорооны дарга гаргана.”

2/9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг:

“9.4. Энэ журмын 9.1-д заасан шийдвэрийг гаргахдаа мөн журмын 13-д заасан тохиромжтой этгээдэд тавигдах шаардлагыг хангасан эсэхийг үндэслэл болгоно.”

2. Мөн журмын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн 2.1.5.5 дахь заалтын “14” гэснийг “13” гэж, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн 9.3.6 дахь заалтын “2.1.7” гэснийг “2.1.12” гэж, 8 дугаар хавсралтын 6 дахь заалтын “2014” гэснийг “2015” гэж тус тус өөрчилсүгэй.

3. Журамд нэмэлт, өөрчлөлтийг оруулж хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000153